

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН МУЗЕЙН БОЛОВСРОЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ , ОЛОН НИЙТИЙН ХӨТӨЛБӨР

Музейн нэр: Аймгийн Музей

Тайлбарлагч, боловсролын ажилтан:М.Айсулу

Холбогдох утасны дугаар: 99543767

№	Боловсрол танин мэдэхүйн ажил болон олон нийтийн хөтөлбөрийн нэр	Зорилго	Зорилтод бүлэг	Хэрэгжиж эхэлсэн он болон үргэлжлэх хугацаа	Тайлбар Музейд болон музейгээс гадуур хэрэгждэг эсэх
1.	“Өв соёлоо ирээдүйд” олон нийтийн хөтөлбөр	Өвөг дээдсээс уламжлагдан ирсэн өв соёл, зан заншлыг сургах, сурталчлан таниулах түгээн дэлгэрүүлэхэд оршино.	Сургуулийн өмнөх насны хүүхэд багачууд, ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчид	2019-2028 он	Уламжлалт тоглоом наадгай үйчүүр, хорол, тогыз хумалах /есөн хоргол/ тоглоомыг зааж сургах, сурталчлан таниулах. -Танхимын хэлбэрээр зохион явагддаг.
2.	“Би Монгол хүүхэд” боловсрол танин мэдэхүйн олон нийтийн хөтөлбөр	Жил бүрийн сар шинийн баяр болон үндэсний баяр наадмыг тохиолдуулан Монголын уламжлалт зан заншил баяр ёслолын зан үйлээс суралцах, ёс заншилтай холбоотой уралдаан, танин мэдэхүйн тэмцээн болон үндэсний тоглоом наадгайг танин мэдүүлэх түгээн дэлгэрүүлэхэд оршино.	Сургуулийн өмнөх насны хүүхэд багачууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид	2024-2028 он хүртэл	Музейн боловсролын хөтөлбөр нь танин мэдэхүйн лекц, сургалт семинар, уралдаан тэмцээн, тоглоом наадгай, дугуйлан, болон сэдэвчилсэн аялал хэлбэрээр хөтөлбөр хэрэгжинэ.
3.	"Гэр бүлээрээ Музейд" олон нийтийн хөтөлбөр	Гэр бүлийн гишүүдийн дунд танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион байгуулах уламжлалт тоглоом наадгай тоглуулах алдаршуулах, идэвх оролцоог нэмэгдүүлэх хамтын ажиллагааг сайжруулах	Сургуулийн өмнөх насны хүүхэд багачууд, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид насанд хүрэгчид, ахмад настан	2024-2028 он хүртэл	-Музейн үзмэрүүдийг бага насны хүүхдүүдийн сэтгэхүйн онцлогт тохируулан тайлбарлах. -Гэр бүлээрээ шагайн наадгайгаар хамтран тоглох.

					-Соёлын биет бус өвийг таниулах, соёлын өвөөрөө бахархах, соёлын өвийн үнэ цэнийг мэдэх.
4.	"Түүхэн хүн болон бахархалт өв" олон нийтийн хөтөлбөр	Нутаг орныхоо баатарлаг гавьяат, эрдэм мэдлэгт, зураачид, ардын жүжигчид, зохиолчид түүхэн хүмүүсийн бүтээл, баатарлаг зүйлсийг алдаршуулах хойч үедээ танин мэдүүлэх, бахархах сэтгэгдлийг төрүүлэн тэдний бүтээлээс танилцан суралцах. /нутгийн бахархал/	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид насанд хүрэгчид, ахмад настан	2024-2028 он хүртэл	-Тайлбарт аялал. -Эх оронч үзэл төлөвшүүлэх.
5.	"Ирвэс" олон нийтийн хөтөлбөр	Цоохор ирвэсийн өлгий нутагт болсон өндөрлөг уулст амьдардаг эко системийн тогтвортой байдлыг хадгалах гайхамшигт амьтныг хойч үедээ сурталчлан таниулах улмаар VR /виртуал/ шинэ технологиор ирвэс хөтөлбөрөө сонирхолтой хэлбэрээр үзүүлэх	Сургуулийн өмнөх насны хүүхэд багачууд, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид насанд хүрэгчид, ахмад настан	2024-2028 он хүртэл	-VR шинэ төхөөрөмжийг хүүхэд багачуудад сонирхуулан "Миний цоохор найз" анимейшинийг үзүүлэх. -Миний бүтээсэн анхны ном "Уулын эзэн" ном бүтээх.
6.	"Уламжлалт гэр сууц" олон нийтийн хөтөлбөр	Зуны улиралд музейгээр аялсан үзэгч олон түмэнд нүүдэлчдийн уламжлалт сууцын хийц, гар болон эсгий урлал, дотоод зохион байгуулалтын биелэгдэл, нүүдэлчдийн бүтээлч, өвөрмөц сэтгэлгээ, ур дүйг уламжлуулах хосгүй үнэт соёлын өвийг хойч үедээ сурталчлан таниулан, түгээн дэлгэрүүлнэ.	Сургуулийн өмнөх насны хүүхэд багачууд, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид насанд хүрэгчид, ахмад настан	2024-2028 он хүртэл	- Эсгий гэрийн түүхэн гарал үүслийн талаар мэдлэг олгох. -Дэлхийн нүүдэлчдийн эсгий гэрийн онцлог, нэршил, гадаад үзэмж, эсгий гэр бүтээх технологийн талаар сурталчлан таниулах. -Танхимын бус хэлбэрээр зохион байгуулагддаг.
7.	"Гэрэлт ертөнц" олон нийтийн хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх, асран хамгаалагч болон эцэг эхчүүдийн хамт шагай тоглох, зураг зурах, хэл ярианы чадвараа хөгжүүлэн өдрийг хөгжилтэй өнгөрүүлэхэд оршино.	Сургуулийн өмнөх насны хүүхэд багачууд, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид	2024-2028 он хүртэл	-Соёлын өвийн дурсгалт газар агуулагдаж байгаа мэдээлэл, мэдлэгийг хүргэх, мэдлэг ба соёлд хөгжлийн бэрхшээлтэй

			насанд хүрэгчид, ахмад настан		иргэдийг оролцуулах, мэдлэгийн хүрээг тэлж, хамтран суралцахыг санал болгох.
8.	“Тусгай хөтөлбөр” – үүд олон нийтийн хөтөлбөр	Тусгай тэмдэглэлт ой, түүхэн үйл явдалтай холбоотой арга хэмжээнүүд болон сургуулийн өмнөх насны боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн сэдэвтэй уялдуулан музейн соёлын өвийн тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Соёлын өв болон хичээлийн сэдэвт уялдуулан илтгэл, эсээ бичих уралдаан тэмцээн, олон нийтэд зориулсан үзэсгэлэн, арга хэмжээнүүдийг зохион байгуулахад оршино.	Сургуулийн өмнөх насны хүүхэд багачууд, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид насанд хүрэгчид, ахмад настан	2024-2028 он хүртэл	Тусгай хөтөлбөрт тэмдэглэлт хаврын “Наурыз баяр”, Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Олон Улсын Музейн өдөр, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Үндэсний бичиг үсгийн өдрүүдийг тохиолдуулан бүх насныханд сэдэвт ажлууд зохион явуулна.